БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ
Х.НЯМБААТАР

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
Г.МӨНХБААТАР

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН УЛСЫН ХЯНАН БАТАЛГАА ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны .....дугаар сарын .....-ны өдөр

Дугаар..... 20 НГЗБА/20250101015-02

Улаанбаатар хот

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	- Газрын тухай хуулийн 58 дугаар зүйл; - Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам"; - Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 24/26 дугаар тогтоолоор батлагдсан нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө; - Нийслэлийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө .
2.	Ажлын зорилго	Газрын тухай хуульд заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэж, өмнөх хянан баталгааны үр дүнтэй харьцуулан дүгнэлт гаргах, мониторингийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэх, мэдээллийн санг баяжуулахад энэхүү ажлын зорилго оршино.
3.	Хамрах хүрээ	Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт нийт 120,063 га газарт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг гүйцэтгэж, газрын мониторингийн сүлжээний цэгийг өтгөрүүлсэн байна.
4.	Ажлын иж бүрдэл	***А. Сонгинохайрхан дүүргийн нийт нутаг дэсвгэрийн хэмжээнд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг дараах төрлүүдээр хийнэ. Үүнд:*** 1. Хот, тосгон, бусад суурины газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа; 2. Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа; 3. Тариалан болон атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа; 4. Зам, шугам сүлжээний газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа (Газар ашиглалтаас шалтгаалж Хот тосгон бусад суурин, бэлчээрийн газрын аргачилсан зааварыг ашиглаж гүйцэтгэх); 5. Ойн сан бүхий газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа (Газар ашиглалтаас шалтгаалж

		Хот тосгон бусад суурин, бэлчээрийн газрын аргачилсан зааварыг ашиглаж гүйцэтгэх); 6. Усны сан бүхий газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа (Газар ашиглалтаас шалтгаалж Хот тосгон бусад суурин, бэлчээрийн газрын аргачилсан зааварыг ашиглаж гүйцэтгэх); 7. Тусгай хамгаалалттай газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа (Газар ашиглалтаас шалтгаалж Хот тосгон бусад суурин, бэлчээрийн газрын аргачилсан зааварыг ашиглаж гүйцэтгэх); 8. Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журмын дөрөвдүгээр бүлэгт заасны дагуу газрын хянан баталгааны тогтвортой үзүүлэлтийг газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр тодорхойлсон байх. ***Б. Ажил хүлээлгэн өгөх иж бүрдэл:*** 1.Хянан баталгааны ажлын тайлан (цаасан, тоон хэлбэрээр) боловсруулж, тайланг тоон хэлбэрээр дараах байдлаар захиалагчид хүлээлгэн өгнө. Үүнд: - Үндсэн тайлан газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр (Songinokhairkhan_tailan.doc болон khan-uul_tailan. pdf); - Нэгдсэн хүснэгт (Songinokhairkhan_husnegt.xls); - Хянан баталгааны нэгж талбарын дүгнэлт (Батлагдсан аргачилсан зааврын дагуу нэгж талбарыг дугаарлаж .doc болон .pdf); - Мониторингийн цэгийн хувийн хэрэг (Батлагдсан аргачилсан зааврын дагуу нэгж талбарыг дугаарлаж .doc болон .pdf) ; - Хянан баталгааны сүлжээний зураг. 2. Мониторингийн мэдээллийн санг доорх давхаргатай үүсгэнэ. Үүнд: 2.1 Хот тосгон, бусад суурины газрын - Үндсэн болон дэд нэгж талбар; - Газрын гадаргын эвдрэл, бохирдлын талбай; - Мониторингийн цэг; - Хөрсний дээж; - Ургамлын бичиглэл; - Ундны усны дээж. 2.2 Бэлчээрийн газрын - Бэлчээрийн нэгж талбар; - Бэлчээрийн төрх байдал; - Бэлчээрийн нөлөөлөл; - Мониторингийн цэг; - Ургамалын бичиглэл хийсэн цэг; - Хөрсний бичиглэл, - Хөрсний дээж. 2.3 Тариалангийн газрын - Тариалангийн газар; - Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалсан талбай; - Атаршсан газар; - Дээж авсан цэг; - Мониторингийн цэг. 2.4. Зам, шугам сүлжээний газрын - Үндсэн болон дэд нэгж талбар; - Газрын гадаргын эвдрэл, бохирдлын талбай; - Мониторингийн цэг;

		- Үндсэн болон дэд нэгж талбар; - Газрын гадаргын эвдрэл, бохирдлын талбай; - Мониторингийн цэг; - Хөрсний дээж; - Ургамлын бичиглэл; - Ундны усны дээж. 2.5. Ойн сан бүхий газрын - Үндсэн болон дэд нэгж талбар; - Газрын гадаргын эвдрэл, бохирдлын талбай; - Мониторингийн цэг; - Хөрсний дээж; - Ургамлын бичиглэл; - Ундны усны дээж. 2.6. Усны сан бүхий газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа - Үндсэн болон дэд нэгж талбар; - Газрын гадаргын эвдрэл, бохирдлын талбай; - Мониторингийн цэг; - Хөрсний дээж; - Ургамлын бичиглэл; - Ундны усны дээж. 2.7. Тусгай хамгаалалттай газрын - Үндсэн болон дэд нэгж талбар; - Газрын гадаргын эвдрэл, бохирдлын талбай; - Мониторингийн цэг; - Хөрсний дээж; - Ургамлын бичиглэл; - Ундны усны дээж. 3. Хавсралт материалыг мониторингийн цэгийн дугаараар нэг хавтаст хийж архивын шаардлага хангасан байдлаар бэлтгэж,, тоон хэлбэрээр дараах байдлаар захиалагчид хүлээлгэн өгнө. Үүнд: - Хээрийн судалгааны фото зураг (Heer_photo.jpg); - Сканердсан ургамлын бичиглэл (urgam_bichiglel.pdf); - Сканердсан хөрсний бичиглэл (hurs_bichiglel.pdf); - Лабораторийн шинжилгээний дүн (dun_shinjilgee.pdf); - Боловсруулалт хийсэн агаар, сансрын зураг (Songinokhairkhan_satellitename.tiff); - ArcGIS ажлын файл (Songinokhairkhan_mxd.mxd); - Тоон мэдээллийн нэгдсэн сан (Songinokhairkhan_gdb.gdb). 4. Газрын мониторингийн цахим системд дараах мэдээллийг оруулна. Үүнд: - Хот тосгон бусад суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлан, тоон мэдээллүүд, хавсралт; - Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлан, тоон мэдээллүүд, хавсралт; - Тариалан болон атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлан, тоон мэдээллүүд, хавсралт; - Зам, шугам сүлжээний газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлан, тоон мэдээллүүд, хавсралт;

		- Ойн сан бүхий газрын газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлан, тоон мэдээллүүд, хавсралт; - Усны сан бүхий газрын газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлан, тоон мэдээллүүд, хавсралт; - Тусгай хамгаалалттай газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлан, тоон мэдээллүүд, хавсралт; - Газрын мониторингийн цэгийн хөрс, ургамлын судалгааны мэдээлэл, хянан баталгааны дүгнэлт, сүлжээний зураг (тоон хэлбэрээр); - Мониторингийн цэгийн мэдээлэл, цэгийн хувийн хэрэг.
5.	Гүйцэтгэх ажлын үе шат, хэмжээ	**5. Бэлтгэл ажлын үе шат** - Хянан баталгаа хийх газрын газарзүйн нөхцөл, газрын нөөцийн судалгаа, мэдээллийг цуглуулж нэгтгэн дүгнэх, зураглах; - Газрын кадастрын мэдээллийн санд үндэслэн хянан баталгаа хийх газрын зориулалт, байршил, хэмжээ, газрын эрхийн талаар судлах; - Өмнө нь хийгдсэн хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлт болон шаардлагатай бусад материалыг холбогдох газраас хуулбарлан авч харьцуулан дүн шинжилгээ хийх, тоон хэлбэрт хөрвүүлэх; - Өмнө нь хийгдсэн хянан баталгааны ажлын хүрээнд тодорхойлсон мониторингийн цэгийн байршил, шинээр байгуулах шаардлагатай мониторингийн цэгүүдийг судлан төлөвлөх, газрын кадастрын зураг, суурь зургуудтай давхцуулж, ажлын зураг зохиох, хянан баталгааны байнгын ажиглалтын талбар болон дэд нэгж талбарыг нарийвчлан тодорхойлж ажлын зурагт тусгах; - Хээрийн судалгаанд ашиглах өндөр нарийвчлал бүхий хиймэл дагуулын болон дроны загвар хүчин чадлын мэдээллийг захиалагчид хүргүүлэх; - Хээрийн судалгааны ажлын төлөвлөгөө боловсруулах; - Хээрийн судалгаанд шаардлагатай багаж хэрэгсэл, программ хангамжийг бэлтгэх. **6. Хээрийн судалгааны үе шат** - Одоо байгаа мониторингийн цэг болон шинээр байгуулж буй мониторингийн цэг тус бүрээс хөрсний дээж авч хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэх, ургамлын бичиглэл хийх; - Байнгын ажиглалтын талбарт буй гадаргын ус, худаг, уст цэгээс усны дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэх; - Хөрсний зулгаралт, элэгдэл эвдрэл, нөхөн сэргээлтийн байдлыг тодорхойлон ажлын зурагтай тулган нарийвчлах; - Өндөр нарийвчлал бүхий сансрын зураг, дроны зургаас газрын гадаргын механик өөрчлөлт, хөрс-ургамлан нөмрөгийн төлөв байдлыг тодруулан, ажлын зурагтай давхцуулан өөрчлөлтийн хил заагийг тогтоох;

		- Хог хаягдлаар бохирдсон газрын байршлыг 2 долгионы GPS болон гар GPS ашиглан тогтоож, хамрах хүрээг зураглах, доройтсон газрын фото зургийг авч баримтжуулах. - Байнгын ажиглалтын талбарт байгалийн болон хүний үйл ажиллагааны улмаас элэгдэж эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээг тодорхойлох, доройтсон газрын фото зургийг авч баримтжуулах; - Байнгын ажиглалтын талбарт буй хог ургамлын тархалтын хил заагийг тодорхойлох; - Газар ашиглалтын аюулгүй байдал, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх үзүүлэлтийг судлан тогтоох. **7. Материал боловсруулалтын үе шат** - Хөрсний лабораторийн задлан шинжилгээний хариуг үндэслэн дүн шинжилгээ хийх, үр дүнг нэгтгэх; - Хөрсний лабораторийн задлан шинжилгээний дүнгээр бохирдол илэрсэн цэгүүдийн бохирдлын хил заагийг тогтоон зураглах, бохирдуулагч эх үүсвэрийг тодорхойлох; - Хөрсний механик бүрэлдэхүүн, карбонат, чулуужилт, элсэн хуримтлал, ялзмагт давхаргын нимгэрэлтийг тодорхойлох; - Хянан баталгааны үзүүлэлт бүрийг өмнөх хянан баталгааны үр дүнтэй харьцуулах, хээрийн судалгаагаар тодорхойлсон элэгдэл, эвдрэл, доройтолд өртсөн газруудын талбайн хэмжээг нэгтгэн дүгнэх, зурагт оруулах; - Элэгдэж эвдэрсэн газар, бохирдсон газрыг нарийвчлан тогтоож зурагт оруулах; - Газар хамгаалах, нөхөн сэргээлт хийх шаардлагатай байршлуудыг тогтоон зураглах; - Судалгаагаар тодорхойлогдсон газрын төлөв байдал, чанар, нөлөөллийн бүх үзүүлэлтийг кодлон, ажлын зурагтай холбон, мэдээллийн сан үүсгэж, хянан баталгааны дэлгэрэнгүй хүснэгтийг боловсруулах; - Хянан баталгааны тайлан, дэд нэгж талбар бүрийн сүлжээний зураг, дүгнэлтийг эцэслэн боловсруулах; - Мониторингийн цэгийн хувийн хэрэг хөтлөх. **8. Ажлыг хянуулах, хүлээлгэн өгөх** - Хянан баталгааны ажлын тайланг захиалагч байгууллагаар хянуулах, захиалагчаас ирүүлсэн шаардагдах засваруудыг гүйцэтгэх; - Ажлын эцсийн үр дүнг Газрын мониторингийн цахим системд оруулах; - Ажлын эцсийн үр дүнг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд тайлагнаж, хүлээлгэн өгөх.
6.	Техникийн шаардлага	- Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”;

		- Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолоор батлагдсан “Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоо”; - Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан “Аргачилсан заавар батлах тухай”; - ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/306 дугаар тушаалаар батлагдсан “Мэдээллийн сангийн загвар батлах тухай”; - Байгаль хамгаалал, хөрс шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 3298-90; - Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019; - Тариалангийн газрын хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга, MNS 6988:2022; - Хөрсөнд эрүүл зүйн нян судлалын шинжилгээ хийх арга MNS 6341:2012; - Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ MNS 3297:1991; - Газар зүйн мэдээллийн системийн ArcGIS программ хангамжийг ашиглан тоон зургийг боловсруулах; - Сүүлийн 12 сарын хугацаанд авсан 10 хүртэлх метрийн орон зайн шийдэлтэй сансрын зураг ашиглах; - Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (Дрон)-ы зураг ашиглах; - Зайнаас тандан судлалын арга зүй ашиглах, тухайн мэргэжлийн боловсон хүчинтэй байх; - Ажлын тайланг Arial, 12 фонтоор, мөр хоорондын зай 1.15, хуудасны дээд захаас 20 мм-ээс доошгүй, доод захаас 20 мм-ээс доошгүй, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм байхаар боловсруулна.
7.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс эхэлж 6 сарын хугацаанд дуусна.
8.	Ажлын хяналт шалгалт	- Захиалагчийн хяналтын зардлыг нийт үнийн дүнгийн 3 (гурав) хувиар тооцно. - Захиалагчийн хяналтыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газар ашиглалт, мониторингийн хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн Газар зохион байгуулалтын нэг, хоёрдугаар алба хамтран гүйцэтгэнэ. Шаардлагатай үед ГЗБГЗЗЕГ-ын Газрын мониторингийн хэлтсийн холбогдох албан хаагчид хамтран хийнэ. - Захиалагч ажлын 3 үе шатанд хяналт тавих бөгөөд хэзрийн судалгааны ажлын хяналтыг тус ажил гүйцэтгэх явцад хийнэ. - Гүйцэтгэгч гэрээнд тусгасан хугацаанд 3 үе шатны тайланг ирүүлнэ. - Захиалагч ажил шалгасан акт гаргаж, хяналтын ажлыг баталгаажуулна.
9.	Салбарын архивын хэлтэст хүлээлгэн өгөх материал	- Бэлтгэл ажлын үе шатны тайлан, цаасан хэлбэрээр- 3 хувь, тоон хэлбэр /DVD/-ээр - тус бүр 3 хувь;

		- Хээрийн ажлын үе шатны тайлан, цаасан хэлбэрээр- 3 хувь, тоон хэлбэр /DVD/-ээр - тус бүр 3 хувь; - Эцсийн үе шатны тайлан, цаасан хэлбэрээр- 3 хувь, тоон хэлбэр /DVD/-ээр - тус бүр 3 хувь; - Агаар, сансрын зураг – 3 хувь /DVD/.
10.	Захиалагч байгууллага	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
11.	Гүйцэтгэгч байгууллага	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа болон газар зохион байгуулалтын төлөвлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.
12.	Санхүүжилт, эх үүсвэр	246,000,000 /хоёр зуун дөчин зургаан сая/ төгрөг, нийслэлийн төсвийн хөрөнгөөр
13.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг гэрээний нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

___oOo___